

БАТЛАВ.

Эм эргэлтийн сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн
2018 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 04 дүгээр хуралдаанаар

**ЛУУС СУМЫН ЭМИЙН ЭРГЭЛТИЙН САНГИЙН ДОТООД ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

НЭГ. Ерөнхий зүйл

МУ-ын Засгийн газрын 2011 оны 11-р сарын 9-ний өдрийн 311-р тогтоолыг үндэслэн боловсруулав.

1. Энэхүү журмын зорилго нь Луус сумын эмийн эргэлтийн сангийн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
2. Энэхүү журмыг эмийн эргэлтийн сан, түүний удирдах зөвлөл дагаж мөрдөнө.
3. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа ЗГ-ын 2011 оны 11-р сарын 9-ний өдрийн 311-р тогтооюор батлагдсан дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам болон Монгол Улсын "Эрүүл мэндийн тухай", "Эм эмнэлэгийн хэрэгслийн тухай" хууль тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, эмийн сангийн үйл ажиллагаанд дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм журам, норм норматив, стандарт шаардлагын хэрэгжилтийг хангах шийдвэрүүдийг удирдлага болгоно.

ХОЁР: Дотоод хяналт шалгалтын зарчим, зорилго, хамрах хүрээ

- 2.1. Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, нээлттэй, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөнөөс ангид байх зарчимд сууринла.
- 2.2. Хяналт шалгалтын ажилтны эрх үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дотоод хяналт шалгалт хийх явцад аливаа дарамт шахалт үзүүлэх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцох буюу нөлөөлөхийг хориглоно.
- 2.3. Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдлийг эрт илрүүлэх, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж эрсдэлгүй байх нөхцлийг бүрдүүлэх
- 2.4. Дотоод хяналт шалгалтын зорилго нь байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж байгаа ажил үйлчилгээний чанар стандарт шаардлага нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, зааварт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээг авна.
- 2.5. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөлийн гишүүн байна.

**ГУРАВ: Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах чиглэл,
хяналт тавих ажилтны эрх, үүрэг**

- 3.1. Хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын чиглэл, удирдамж төлөвлөгөөг удирдах зөвлөлөөр хэлэлцэж засаг дарга батална.
- 3.2. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь засаг даргын удирдлаганд ажиллах бөгөөд хяналт хийх явцад хараат бус байна.
- 3.3. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь ЭЭСангийн үйл ажиллагааны онцлогийн талаар мэдлэг мэдээлэлтэй байхаас гадна үүрэг чиглэл өгөх ажлын дадлага туршлагатай байна.
- 3.4. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь хяналт шалгалтын дүн, авсан арга хэмжээний талаар ЭЭСҮЗөвлөлийн хуралд тайлагнан хэлэлцүүлж шаардлагатай бол зохих шийдвэр гаргуулан хэрэгжилтийг хангуулна.

3.2. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь дараах эрх үүрэгтэй байна.

- 3.2.1 Зохих удирдамж төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэж танилцуулга мэдээлэл бэлтгэн дүнг тайлагнах
- 3.2.2 Хяналт шалгалтыг явуулахдаа засаг дарга болоод эмийн сангийн эрхлэгчтэй шууд харилцаж тэдгээрээс шаардлагатай мэдээлэл авах судалгаа гаргуулах

- 3.2.3 Илэрсэн зөрчил дутагдлын шалтгаан нөхцлийг тодруулан зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх дахин давтахгүй байх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- 3.2.4 Холбогдох дүрэм журам, байгууллагын үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар санал дүгнэлт гаргах
- 3.2.5 Дотоод хяналтын үр нөлөө чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас / МХГ –аас / мэргэжил арга зүйн зөвлөгөө тусламж авах, зөрчлийг арилгаж чадахгүй асуудлыг хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах
- 3.2.6 Дотоод хяналт шалгалтаар иргэдийн эрүүл мэнд, амь насанд шууд болон шууд бусаар ноцтой аюул хор хохирол учруулж болзошгүй нөхцөл байдал үүссэхээр болсон нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг даруй авч эрх бүхий байгууллагад мэдэгдэх

ДӨРӨВ. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа

4.1. Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна.

- 4.1.1. Хууль тогтоомж, болоод мэргэжлийн байгууллагаас гаргасан шийдвэрүүдийн хэрэгжилтэнд тавих хяналт шалгалт
- 4.1.2. Иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, боловсрол олгох сургалт сурталчилгаа мэдээллээр хангах байдалд тавих хяналт
- 4.1.3. ЭЭСангийн ажилтны ажиллах нөхцөл, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад тавих хяналт шалгалт
- 4.1.4. ЭЭСангийн ажил үйлчилгээний чанар, стандарт шаардлагад тавих хяналт шалгалт
- 4.1.5. Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт

ТАВ. Хариуцлага

- 5.1. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг ногдуулна.
- 5.2. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

Удирдах зөвлөл

ЭЭСангийн дотоод хяналт шалгалтын журмын нэгдүгээр хавсралт

ДОТООД ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛ, АЖИЛТНУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

2018.06.18

№	Дотоод хяналт шалгалтын чиглэл	Хариуцан ажиллах дотоод хяналтын ажилтан	Дотоод хяналтын ажилтны үйл ажиллагааны чиг үүрэг
1	Эмийн сангийн үйл ажиллагаанд мөрдвөл зохих хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативын шаардлагыг хэрэгжүүлэх, түүнд тавих хяналт	УЗ-ийн нарийн бичгийн дарга / Г.Наранжаргал /	<ul style="list-style-type: none"> ✓ Холбогдох дүрэм журам заавар стандарт шаадлагын хэрэгжилтэнд хяналт тавих, мэргэжлийн удирдлагаар хангах ✓ МХГ-ын хяналт шалгалтын хуудсаар үнэлгээ хийж эрсдлийг урьдчилан тооцох, эрсдлийг багасгах ✓ Ажлын төлөвлөлт баталгаажилт ✓ Дотоод хяналт шалгалтыг тогтмолжуулах удирдлагаар хангах ✓ Шаардлагатай эмийн нөөц хангарт, Эмийн хадгалалт, хамгаалалт, олголтонд хяналт тавих ✓ Эмийн цахим жор бичилтийг нэвтрүүлж хэвшүүлэх
2	Төсөв санхүүгийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнант ил тод нээлттэй байдал, шилэн данс хөтлөлт, байршуулалт	УЗ-ийн гишүүн ЖК.Ундрахбаяр /	<ul style="list-style-type: none"> ✓ Төсөв санхүүгийн ил тод нээлттэй байдал, тайлагнант ✓ Байгууллагын гадаад дотоод орчны тохижилт, аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт шаардлага ✓ Ажлын цаг ашиглалт ✓ Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналт ✓ Эмийн үнийн тогтоолтыг хэлэлцүүлж батлах
3	Эмийн санд тавигдах нийтлэг стандарт шаардлагын хэрэгжилтийг хангах	УЗ-ийн гишүүн /Э.Ганчимэг/	<ul style="list-style-type: none"> ✓ Мансууруулах сэтгэцэд нөлөөлөх эмийн орлого зарлага, хадгалалт, олголт, устгалтын хөтөлгөө буртгэлд тавих хяналт ✓ Жороор олгох эмэнд тавих хяналт
4	Ажил үйлчилгээний чанарт тавих хяналт шалгалт	УЗ-ийн гишүүн / Ё. Төгсбаяр /	<ul style="list-style-type: none"> ✓ ЭМДСангас олгогдох хөнгөлөлттэй эмийн жор бичилт, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжинд хяналт үнэлгээ хийх ✓ Үйлчлүүлэгчдийн гомдлыг барагдуулах
5	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэсэн хяналт	УЗ-ийн гишүүн Д.Энхбаатар	<ul style="list-style-type: none"> ✓ Эм олгоходоо зохистой хэрэглээний талаар зөвлөх, шинэ эмийн мэдээлэл, хэрэглэх заавар, хадгалалт, гаж нөлөөнөөс сэргийлэх талаар иргэд болоод эмнэлэгийн ажилтнуудад зөвлөгөө өгдөг эсэхэд тавих хяналт ✓ Эйн үнийн тогтоолтонд тавих хяналт

ЭЭСангийн дотоод хяналт шалгалтын
журмын хоёрдугаар хавсралт

2018.06.18

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГРАФИК

Улирал

1 улирал	2 улирал	3 улирал	4 улирал
-------------	-------------	-------------	-------------

Хариуцах
эзэн

Хяналт шалгалтын чиглэл		Улирал				Хариуцах эзэн
1	2	3	4	улирал	улирал	
1 Дотоод хяналт шалгалтын журам боловсруулан , ажлын график төлөвлөн танилцуулж зөвлөлөөрөө хэлэлцэж батлах						Засаг дарга
2 Хууль эрх зүйн актын мөрдөлтөнд тавих хяналт						Наранжаргал
3 Ажлын төлөвлөлт баталгаажилт тайлагнант						Дашзэгвэ, Цогзолмаа
4 Ажлын цаг ашиглалт						Дашзэгвэ
5 Байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээ ариун цэвэр эрүүл ахуй тохижилт соёлжилт						Ундрахбаяр
6 Үйлчлүүлэгчдийн гомдол шүүмжлэлийг хүлээн авах барагдуулах						Дашзэгвэ Ундрахбаяр
7 Иргэдэд ажлаа тайлагнах сургалт сурталчилгааг тогтмолжуулах						Цогзолмаа
8 Эмийн татан авалт нөөц хангалт хадгалалт хамгаалалт						Дашзэгвэ
9 МХГ-ын хяналт шалгалтын хуудсаар урьдчилсан үнэлгээ хийж эрсдлийг тооцож бууруулахад чиглэсэн арга хэмжээ авах						Наранжаргал
10 Шаардлагатай эмийн нөөц хангалт, үнэ тогтоолт, эмийн хадгалалт, хамгаалалт, олголт						Наранжаргал
11 Эмийн цахим жор бичилт						Ганчимэг
12 Мансууруулах сэтгэцэд нөлөөлөх эмийн орлого зарлага, хадгалалт, олголт, устгалтын хөтөлгөө бүртгэлд тавих хяналт						Наранжаргал
13 Жороор олгох эмэнд тавих хяналт						Ганчимэг
14 ЭМДСангаас олгогдох хөнгөлөлттэй эмийн жор бичилт, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжинд хяналт тавих үнэлгээ хийх						Наранжаргал
15 Үйлчлүүлэгчдийн гомдлыг барагдуулах						Төгсбаяр
16 Эм олгоходоо зохистой хэрэглээ, шинэ эмийн мэдээлэл, хэрэглэх заавар, хадгалалт, гаж нөлөөнөөс сэргийлэх талаар иргэд болоод эмнэлэгийн ажилтнуудад зөвлөгөө өгдөг эсэх						Ганчимэг
						Төгсбаяр
						Энхбаатар
						Энхбаатар

ЭЭСангийн төлөөлөн удирдах зөвлөл